

## **МУЗЕЙД ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЭТГЭЭДЭД ТАВИХ ШАЛГУУР**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж буй музейн үйлчилгээний чанар болон аюулгүй байдлыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагаагаа уялдуулах зорилгоор үнэлгээ хийлгэхдээ энэхүү аргачлалыг баримтална.
- 1.2. Музейн үйлчилгээний чанар болон аюулгүй байдлын үнэлгээг 4 жил тутамд өмчийн хэлбэр, зэрэглэл харгалзахгүй тусгай зөвшөөрөл олгогдсон бүх музейд явуулна.
- 1.3. Энэхүү аргачлалын зорилго нь музейн үйлчилгээний чанар, хүртээмж, музейн аюулгүй байдлын түвшинг тодорхойлох, түүний мөрөөр сайжруулах боломж, эн тэргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоход оршино.
- 1.4. Музейн үнэлгээг хийхэд Музейн тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох бусад эрх зүйн актыг баримтална.
- 1.5. Музейн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг сунгахдаа Музейн үйлчилгээний чанар аюулгүй байдлын үнэлгээ, түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг харгалзана.

### **Хоёр. Үнэлгээ хийх этгээдэд тавих шалгуур**

- 2.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга музейн үйлчилгээний чанар болон аюулгүй байдлын үнэлгээг тухайн музейтэй хамааралгүй дараах шалгуурыг хангасан иргэн, хуулийн этгээд /цаашид “үнэлээч” гэх/-ээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ.
- 2.2. Үнэлээч нь дараах шалгуур үзүүлэлтийг хангасан байна. Үүнд:
  - 2.2.1. Музей, соёлын өв, онцгой байдал, барилга болон хяналтын чиглэлээр 5-аас дээш жил ажиллаж, мэргэшсэн туршлагатай байх;
  - 2.2.2. Мэргэжлийн/ эрх бүхий байгууллагаас зохион байгуулсан музейн үнэлгээний мэдлэг олгох сургалтад хамрагдаж, тусгай зөвшөөрөл авсан байх; /судлах/
  - 2.2.3. Үнэлээч тухайн музейн нутаг орны онцлог, нийгэм, эдийн засаг байдлыг музейн үзэл баримтлалтай уялдуулан бодитой, үнэн зөв дүгнэлт гаргах, үүний үндсэн дээр үзмэрийг хадгалалт, хамгаалалт болон музейн үйл ажиллагааг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах санал, зөвлөмж боловсруулах чадвартай байх;
  - 2.2.4. Үнэлээч нь үнэлгээ хийхэд шаардлагатай дараах мэдээллийг цуглуулан шинжилсэн байх. Үүнд:
    1. Музейн үзэл баримтлал
    2. Музейн стратеги төлөвлөгөө
    3. Музейн үзүүлэлт дэглэлтийн төлөвлөгөө

4. Музейн гамшгаас хамгаалах төлөвлөгөө
  5. Музейн үйлчилгээний орчин, аюулгүй байдал
  6. Музейн боловсролын ажил, түүний хүртээмж
  7. Музейн сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалтын байдал
  8. Музейн сан хөмрөгийн бүртгэл баримтжуулалт
  9. Музейн барилга байгууламжийн стандарт
- 2.3. Үнэлгээ хийх үйл ажиллагааны зардал, үнэлгээчийн урамшууллыг санал тавьсан аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцана.
  - 2.4. Үнэлгээний баг 3-5 хүний бүрэлдэхүүнтэй байх ба *төрийн* болон олон нийтийн зөвлөл, төрийн бус байгууллагын төлөөлөл байж болно.

### **Гурав. Үнэлгээ хийх ажлын зохион байгуулалт**

- 3.1. Үнэлээч музейн ажил байдалтай биечлэн танилцаж, хүсэлт гаргасан этгээдтэй гэрээ байгуулан, удирдамж боловсруулан батлуулж ажиллана.
- 3.2. Үнэлгээг дараах үнэлгээний хуудсаар хийж, дүгнэнэ. Үүнд:
  - 3.2.1. Музейн үйлчилгээний чанарын үнэлгээ
  - 3.2.2. Музейн аюулгүй байдлын үнэлгээ
- 3.3. Үнэлгээг тоо ба чанарт тулгуурлан гаргах ба сүүлийн гурван жилийн үйл ажиллагааг хамааруулан дүгнэнэ.
- 3.3. Үнэлээч үнэлгээг хийхдээ үнэлгээ хийлгэх хүсэлт гаргасан этгээдийн санал болон цаг үеийн нөхцөл байдал, музейн онцлогоос хамааран үнэлгээний нэмэлт хуудас боловсруулан ашиглаж болох ба ингэхдээ батлуулан гэрээ, удирдамжид хавсаргана.
- 3.4. Үнэлгээний ажил дууссаны дараа үнэлгээний дүгнэлт, тайлан түүн дээр үндэслэсэн зөвлөмжийг боловсруулан аймаг, нийслэлийн Засаг дарга, соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.
- 3.6. Үнэлгээний тайланд хүргүүлэх зөвлөмж, үнэлгээний хуудууд болон үнэлгээг хийхэд үндэслэсэн бусад баримтыг хавсаргана.

### **Дөрөв. Үнэлгээг дүгнэх аргачлал**

1. *“үр дүнтэй” – үйлчилгээний чанар, аюулгүй байдлын шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол хэрэгжилт 100 хувь (90-100 хүртэл хувь);*
2. *“тодорхой үр дүнд хүрсэн” – үйлчилгээний чанар, аюулгүй байдлын шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70 хувь (60-89 хүртэл хувь);*
3. *“эрчимжүүлэх шаардлагатай” – үйлчилгээний чанар, аюулгүй байдлын шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай бол хэрэгжилт 40 хувь (31-59 хүртэл хувь);*
4. *“үр дүнгүй” – үйлчилгээний чанар, аюулгүй байдлын шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж*

чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй бол хэрэгжилт 0 хувь (0-30 хүртэл хувь);

----оОо----

Үнэлгээний хуудас №1

### Музейн үйлчилгээний чанарын үнэлгээ

| Ерөнхий мэдээлэл                |  |
|---------------------------------|--|
| Музейн нэр                      |  |
| Музейн өмчийн хэлбэр            |  |
| Тусгай зөвшөөрлийн дугаар /5.3/ |  |
| Тусгай зөвшөөрлийн хугацаа      |  |

| Шалгуур үзүүлэлт                                                                                                           |                                                                                                                                                                                                                                                                      | Суурь<br>оноо | Үнэлсэн<br>оноо | Үнэлсэн<br>онооны<br>тайлбар |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------|-----------------|------------------------------|
| “Музейн үзэл баримтлал”-ын хэрэгжилт                                                                                       |                                                                                                                                                                                                                                                                      |               |                 |                              |
| Музейн төрөл, үйл ажиллагааны чиглэл, хамрах хүрээ, цуглуулгын болон үзүүлэгийн бодлогыг тодорхойлсон баримт бичиг /4.1.2/ |                                                                                                                                                                                                                                                                      |               |                 |                              |
| <b>Музейн сан хөмрөгийн баяжилт /7.1.1/</b>                                                                                |                                                                                                                                                                                                                                                                      | <b>5</b>      |                 |                              |
|                                                                                                                            | Баяжилтаар нэмэгдсэн үзмэрийн тоо                                                                                                                                                                                                                                    | 2             |                 |                              |
|                                                                                                                            | Чанарын үзүүлэлт шаардлага хангасан байдал:<br>- Музейн үзэл баримтлалд нийцсэн - 1 оноо,<br>- ШУ, соёл, урлагийн ач/х -1 оноо<br>- Бүрэн бүтэн байдал -1 оноо                                                                                                       | 3             |                 |                              |
| <b>Үйлчилгээний чанар /7.1.4/</b>                                                                                          |                                                                                                                                                                                                                                                                      |               |                 |                              |
|                                                                                                                            | Угтах үйлчилгээ:<br>- Хүлээн авах танхим<br>- Танилцуулах самбар, цагийн хуваарь, үйлчилгээний үнэ<br>- Мэдээлэх үйлчилгээ<br>- Танилцуулга, тасалбар түүний чанар хүртээмж<br>- Тусгай хэрэгцээт үзэгчдэд зориулсан танилцуулга<br>- Үзүүлэгийн танхимын схем зураг |               |                 |                              |
|                                                                                                                            | Үзэгчийн сэтгэл ханамжийн судалгаа:<br>- Цаасан суурьтай                                                                                                                                                                                                             |               |                 |                              |

|                                        |                                                                                                                                                                                                                                                                                                                         |  |  |  |
|----------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|--|--|
|                                        | - Цахим                                                                                                                                                                                                                                                                                                                 |  |  |  |
|                                        | Үзэгчийн үнэлгээний судалгааны үр дүнд суурилсан ажил, үйлчилгээ /3/ /мэргэжлийн байгууллагаар судалгааны дүгнэлт хийлгэх/                                                                                                                                                                                              |  |  |  |
|                                        | Тусгай хэрэгцээт үзэгчдэд зориулсан үйлчилгээний чанар: <ul style="list-style-type: none"> <li>- Харааны бэрхшээлтэй үзэгчдэд бариал үсгийн тайлбар, аудио хөтөч</li> <li>- Сонсголын бэрхшээлтэй үзэгчдэд дохионы хэлний тайлбар /дэлгэцээр/</li> <li>- Тэргэнцэртэй үзэгчдэд зорчих зам /пандус/- Стандарт</li> </ul> |  |  |  |
|                                        | Худалдаа, үйлчилгээний цэг /7.2/                                                                                                                                                                                                                                                                                        |  |  |  |
|                                        | Музейд холбогдох бэлэг дурсгалын бүтээгдэхүүн /Мерчандайз/                                                                                                                                                                                                                                                              |  |  |  |
|                                        | Амрах хэсэг /ширээ, сандал/                                                                                                                                                                                                                                                                                             |  |  |  |
| <b>Музейн хүний нөөцийн судалгаа</b>   |                                                                                                                                                                                                                                                                                                                         |  |  |  |
|                                        | Музейн удирдлага болон ажилтнуудын ёс зүйн нийтлэг хэм хэмжээг даган мөрдөж буй байдал /17/ /Музейн хууль болон ОУМЗ-ийн ёс зүйн дүрэмд нийцүүлэн боловсруулсан санал асуулгаар үнэлнэ/                                                                                                                                 |  |  |  |
|                                        | Музейн удирдлага болон ажилтнуудын ажлын мэдлэг, ур чадвар                                                                                                                                                                                                                                                              |  |  |  |
|                                        | Музейн олон нийтийн зөвлөл, үйл ажиллагааны үр дүн /5.7/                                                                                                                                                                                                                                                                |  |  |  |
|                                        | Хүний нөөцийг хөгжүүлэх бодлого, хэрэгжилт /3/                                                                                                                                                                                                                                                                          |  |  |  |
| <b>Музейн үйл ажиллагааны хүртээмж</b> |                                                                                                                                                                                                                                                                                                                         |  |  |  |
|                                        | Музейгээс зохион байгуулсан хамтарсан болон бие даасан үзэсгэлэнгийн тоо, чанар: <ul style="list-style-type: none"> <li>- Гадаад оронд</li> <li>- Нийслэл, орон нутагт</li> <li>- Музейн байранд</li> </ul>                                                                                                             |  |  |  |
|                                        | Олон нийтэд зориулсан үйл ажиллагааны тэгш хүртээмжтэй байдал: /насны ангиллаар/ <ul style="list-style-type: none"> <li>- Сургуулийн өмнөх боловсролын нас</li> <li>- 6-16 нас</li> <li>- Оюутнууд</li> </ul>                                                                                                           |  |  |  |

|                                                 |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |  |  |  |
|-------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|--|--|
|                                                 | <ul style="list-style-type: none"> <li>- Насанд хүрэгч</li> <li>- Ахмад настан</li> <li>- Тусгай хэрэгцээт</li> <li>- Гадаад</li> </ul>                                                                                                                                                                                                                                         |  |  |  |
|                                                 | Хэрэгжүүлсэн төслийн тоо, чанар: <ul style="list-style-type: none"> <li>- Хадгалалт хамгаалалт</li> <li>- Эрдэм шинжилгээ</li> <li>- Боловсролын ажил</li> <li>- Үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах /3/</li> </ul>                                                                                                                                                       |  |  |  |
|                                                 | Музейн үзмэр, эд өлгийн зүйлсийн цуглуулгын эргэлтийн тоо, чанар: /8.1/ <ul style="list-style-type: none"> <li>- Үзэсгэлэнд оролцсон үзмэр</li> <li>- Түүнээс анх удаа үзүүлэлт дэглэгдсэн үзмэр</li> <li>- Музей дээр түр хугацаагаар ашигласан соёлын үнэт зүйлийн тоо /7.1.11/</li> </ul>                                                                                    |  |  |  |
|                                                 | Музейн сурталчилгааны тоо чанар: <ul style="list-style-type: none"> <li>- Танилцуулга</li> <li>- Хэвлүүлсэн бүтээл</li> <li>- Контент</li> <li>- Нэвтрүүлэгт оролцсон</li> </ul>                                                                                                                                                                                                |  |  |  |
|                                                 | Музейн хамтын ажиллагаа тоо, чанар: /7.1.9/ <ul style="list-style-type: none"> <li>- Гадаад</li> <li>- Дотоод</li> <li>- Музей хооронд /7.1.12/</li> </ul>                                                                                                                                                                                                                      |  |  |  |
| <b>Музейн боловсролын ажил /7.1.6; 7.1.7/</b>   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |  |  |  |
|                                                 | Зохион байгуулсан ажлын тоо, чанар: <ul style="list-style-type: none"> <li>- Төлөвлөгөө, тайлан</li> <li>- Төрөл, чиглэл</li> <li>- Тэгш хүртээмжтэй байдал</li> <li>- Зорилтот бүлэгт чиглэсэн</li> <li>- Хамрагдсан хүмүүсээс авсан судалгаа</li> <li>- Судалгааны үр дүнд суурилсан ажлыг хэрэгжүүлсэн байдал</li> <li>- Сургалт зохион байгуулсан байдал /7.1.7/</li> </ul> |  |  |  |
| <b>Эрдэм шинжилгээ, судалгааны ажил /7.1.8/</b> |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |  |  |  |
|                                                 | Ажлын тоо, чанар: <ul style="list-style-type: none"> <li>- Дотоодод хэвлэн нийтлүүлсэн</li> <li>- Гадаадад хэвлэн нийтлүүлсэн</li> <li>- Судалгаа шинжилгээнд хамрагдсан үзмэрийн тоо</li> </ul>                                                                                                                                                                                |  |  |  |

|                                                                                  |                                                                                                                                                                                                                                    |  |  |  |
|----------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|--|--|
|                                                                                  | <ul style="list-style-type: none"> <li>- Илтгэл, хэлэлцүүлгийн тоо</li> <li>- Музейн хөгжил болон үзмэртэй холбогдуулан судалсан байдал</li> </ul>                                                                                 |  |  |  |
| <b>Музейн сурталчилгааны ажлын тоо, чанар:</b>                                   |                                                                                                                                                                                                                                    |  |  |  |
|                                                                                  | Ажлын төрөл, тоо, чанар: <ul style="list-style-type: none"> <li>- Веб сайт</li> <li>- Сошиол /facebook, Instagram.../</li> <li>- Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллаж буй байдал /3/</li> </ul>                           |  |  |  |
| <b>Үзэгчдийн тоо</b>                                                             |                                                                                                                                                                                                                                    |  |  |  |
| Дотоодын үзэгчид                                                                 |                                                                                                                                                                                                                                    |  |  |  |
|                                                                                  | Сургуулийн өмнөх боловсролын насны үзэгчдийн тоо                                                                                                                                                                                   |  |  |  |
|                                                                                  | 6-16 насны үзэгчдийн тоо                                                                                                                                                                                                           |  |  |  |
|                                                                                  | Оюутнуудын тоо                                                                                                                                                                                                                     |  |  |  |
|                                                                                  | Насанд хүрсэн үзэгчдийн тоо                                                                                                                                                                                                        |  |  |  |
|                                                                                  | Ахмад настан үзэгчдийн тоо                                                                                                                                                                                                         |  |  |  |
|                                                                                  | Хөгжлийн бэрхшээлтэй үзэгчдийн тоо                                                                                                                                                                                                 |  |  |  |
|                                                                                  | Шинэ үзэгчийн тоо                                                                                                                                                                                                                  |  |  |  |
|                                                                                  | Гадаадын үзэгчид                                                                                                                                                                                                                   |  |  |  |
| <b>Үзүүлэлт дэглэлт /7.1.4/</b>                                                  |                                                                                                                                                                                                                                    |  |  |  |
|                                                                                  | Үзүүлэлт дэглэлтийн төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан /8.1, 8.2, 8.3/                                                                                                                                                                |  |  |  |
|                                                                                  | Үзүүлэлт дэглэлтийн аюулгүй байдал                                                                                                                                                                                                 |  |  |  |
|                                                                                  | Үзүүлэлт дэглэлт, хаяг, тайлбар, танилцуулгын чанар: <ul style="list-style-type: none"> <li>- Танхимын танилцуулга</li> <li>- Үзмэр, эд өлгийн зүйлийн хаяг тайлбар</li> <li>- Дижитал тоног төхөөрөмж ашигласан байдал</li> </ul> |  |  |  |
|                                                                                  | Музейн үзүүлэлт техник, технологийн дэвшил /дижитал, вертуал/-ийг нэвтрүүлсэн байдал                                                                                                                                               |  |  |  |
|                                                                                  | Үзэгчдэд тайлбарт үйлчилгээ /хөтөч, аудио, цахим/ хүргэж байгаа байдал                                                                                                                                                             |  |  |  |
|                                                                                  | Үзүүлэлт дэглэлтийн шинэчлэл хийгдсэн хугацаа /8.1/                                                                                                                                                                                |  |  |  |
|                                                                                  | Үзүүлэлт дэглэлтээ шинэчлэх төлөвлөгөө, төсөл /8.2/                                                                                                                                                                                |  |  |  |
| <b>Бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэлт /7.1.3/, Бүртгэн баримтжуулалт /7.1.2/</b> |                                                                                                                                                                                                                                    |  |  |  |
|                                                                                  | Мэдээллийн сангийн тоноглогдсон хадгаламжийн                                                                                                                                                                                       |  |  |  |

|  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |  |  |  |
|--|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|--|--|
|  | сангийн өрөө, тасалгаатай эсэх                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |  |  |  |
